



НҮҮРС ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1.Өнөөгийн байдал:

Манай аймаг 17 сум, 91 баг 87,3 мянган хүн амтай бөгөөд Жаргалант сумын 12 багт 8082 өрхийн нийт 29,8 мянган бүртгэлтэй байнгын суурьшилтай иргэн амьдарч байгаа хэдий ч Ховд Их сургуулийн оюутан болон бусад бүртгэлгүй иргэдийг оролцуулаад 40,0 мянга гаруй иргэн амьдарч байна. Үүнээс 5300 гаруй өрх нь хашаандаа гэр болон хувийн байшинд амьдардаг бөгөөд өвлийн улиралд түүхий нүүрс түлэн халаалтын асуудлаа шийдвэрлэж байна. Эдгээр түүхий нүүрсийг Хөшөөт, Хотгор, Тарвагатайн нүүрсний уурхайгаас худалдан авч хэрэглэж байна.

1.2.Хөтөлбөрийн зорилго:

Шатахууны үнийн өсөлтийг дагаад жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниуд нүүрсний үнийг хэт их хөөрөгдөхөөс сэргийлэн Жаргалант сумын 5300 гаруй гэр хорооллын айл өрхүүдийг хямд үнэтэй нүүрсээр хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.Жолооч, тээвэрлэгч нартай харилцан ойлголцож нүүрсний хангамж, нөөц, үнийг тогтворжуулах.

2.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудад санхүүгийн дэмжлэгийг тодорхой хугацаанд үзүүлэн буцаан Хот хөгжүүлэх санд төвлөрүүлнэ. Сангийн хөрөнгө нийт 40,0 сая төгрөг байна.

2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд

3.1.Аймгийн Засаг даргын Тамгын газар.

3.2.Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга нар.

3.3.Хөтөлбөрт оролцогчид нь жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниуд байна.

Дөрөв. Хэрэгжүүлэгч талуудын үйл ажиллагаа

4.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа:

4.1.1.Аймгийн Засаг даргын захирамжаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудыг сонгон шалгаруулах.

4.1.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудтай хамтран ажиллах гэрээг байгуулах замаар эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх.

4.1.3.Хамтран ажиллах гэрээний хүрээнд нийлүүлж буй нүүрсний хэмжээ, үнэд хяналт тавих.

4.1.4.Хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хамтран ажиллах гэрээг цуцлах.

4.2. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга нарын үйл ажиллагаа:

4.2.1.Хамтран ажиллах гэрээний хүрээнд нийлүүлж буй нүүрсний хэмжээ, үнэд хяналт тавих.

4.2.2.Хамтран ажиллах гэрээний үүргээ биелүүлээгүй жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудтай байгуулсан гэрээг цуцлах саналыг ажлын хэсэгт ирүүлэх.

4.2.3.Ард иргэдэд нүүрсийг тэгш, хүртээмжтэй олгох ажлыг жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудтай хамтран зохион байгуулж, үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийг Хот хөгжүүлэх санд төвлөрүүлэх.

4.3. Жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниудын үйл ажиллагаа:

4.3.1.Хамтран ажиллах гэрээнд заасны үнээр Жаргалант сумын ард, иргэдэд нүүрс нийлүүлэх.

4.3.2.Хамтран ажиллах гэрээнд заасан санхүүжилтийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээт хугацаандаа ашиглан эргүүлэн төлөх.

4.3.3.Нүүрс тээвэрлэхэд гарах авто машины эвдрэл, элэгдэл, нүүрсний хорогдол болон бусад холбогдох асуудлыг өөрөө хариуцах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2018-2020 он хүртэл хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг санхүүжүүлэх 40,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг “Хөшөөт хөгжил сан”-гаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хот хөгжүүлэх санд төвлөрүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Санхүү, дотоод аудитын албатай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх, аймгийн Засаг даргын Зөвлөлд танилцуулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдэд тайлагнана.

6.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Долоо. Хариуцлага

7.1.Жолооч, тээвэрлэгч, тээврийн компаниуд нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлан гарсан хохирлыг төлүүлэхээр хууль, шүүхийн байгуулагд шилжүүлэх замаар хохирлыг барагдуулна.

7.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хууль бус үйл ажиллагаа явуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн хүрээнд арга хэмжээ авч хохирлыг барагдуулна.

.....oOo.....